



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 1/15

Улаанбаатар хот

Тушаалд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/233 дугаар тушаалаар баталсан "Зорчигч, ачаа тээвэрлэлтийн жишиг тариф"-ын 3 дугаар хавсралтаар "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх тариф тооцох аргачлал"-ыг нэмж баталсугай.

2. "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх тариф тооцох аргачлал"-ыг төсөл, судалгааны ажил боловсруулах, өөрийн санхүүгийн чадамж, ачаа тээврийн эрэлт хэрэгцээ, ачааны онцлог, тээвэрлэх зайд зэргийг харгалзан тээвэрлэлтийн өртөг зардлыг тооцоход ашиглахыг тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөсүгэй.

3. Баталсан аргачлалыг сурталчлан, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ё.Жаргалсайхан), Нийслэлийн нийтийн тээврийн газар (С.Жавхлантбаатар), "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ (Б.Гүрсөронзон)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

С.БЯМБАЦОГТ



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
2019 оны 390 дугаар сарын 5-ны  
өдрийн тушаалын хавсралт

9020050420 5919487 СБА7589

**АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР АЧАА ТЭЭВЭРЛЭХ  
ТАРИФ ТООЦОХ АРГАЧЛАЛ**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**


1.1. Энэхүү аргачлалын зорилго нь автотээврийн хэрэгслээр ачaa тээвэрлэх гэрээ байгуулахад оролцогч талууд харилцан төлөх үнэ хөлс тогтооход мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд оршино.

1.2. Автотээврийн салбарт тээвэрлэлтийн өөрийн өртөг (ажил, үйлчилгээ) нь авто замаар тээвэрлэхэд ашигласан бүх төрлийн (авто тээвэрээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ) зардлын тооцоолол байна.

**ХОЁР. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ӨӨРИЙН ӨРТГИЙН ЗАРДЛЫН  
ЖИШИГ ЖАГСААЛТ**


Хүснэгт 1

д/д	Зардлын нэр	Тайлбар
1	Жолоочийн цалин	Автотээврийн салбарын хамтын тарифын хэлэлцэрээр тогтоосноос багагүй, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтуудад нийцүүлэн ажил олгож, ажилтны хооронд гэрээгээр зохицуулагдах бөгөөд тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтын шийдвэр гарсан байх
2	Жолоочийн цалингаас суутгах шимтгэл	Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу дааттуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ 11,5 /хувиар/ байна
3	Шатахуун	Зардлыг тооцоолохдоо, "Жишиг норм батлах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 100км гүйтэд зарцуулах шатахууны жишиг норм, 2 дугаар хавсралтын шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нехцелүүд 3 дугаар хавсралтын автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээг баримтална.
4	Тосолгооны болон бусад ашиглалтын материал	Шатахууны үнийн дүнгийн 3,0-6,0 хувиар
5	Резин дугуйн элэгдэл, хорогдолын зардал	"Жишиг норм батлах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтын 5.1. автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйтлийн нормыг жишиг болгон тооцно.
6	Төлөвлөгөөт засвар үйлчилгээний зардал (ТҮ, Улирлын үйлчилгээ, хугацаат эд анги, сэлбэг солих)	"Жишиг норм батлах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтын хүснэгт 5.4. зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаар, хүснэгт 5.5. автомашины үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний доод хязгаар зэргийг баримтлана.



7	Төлөвлөгөөт бус засварын зардал (шинэ сэлбэг)	Шатахууны үнийн дүнгийн 4,0-10,0 хувиар
8	Хөдлөх бүрэлдэхүүний элэгдэл	"Жишиг норм батлах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтын автомашины эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйтлийн нормыг баримтлана.
9	Даатгал (Жолоочийн хариуцлагын, тээврийн хэрэгслийн, ачааны даатгал)	Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу заавал даатгуулна. Бусад даатгалыг сайн дурын үндсэн дээр хийлгэх бөгөөд тээвэрлэгч нь зардалдаа тусган тооцох боломжтой
10	Техникийн хяналтын үзлэгийн төлбөр	"Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах давтамж, оношилгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол
11	Логистикийн зардал	Ачааг ачих, буулгах, жигнэх, зөөвөрлөхөд гарах зардлыг гэрээ болон тогтоосон үнэ, зах зээлийн ханшийн дагуу харилцан тохиролцсоноор тусгах
12	Авто зогсоол, авто зам ашигласны төлбөр хураамж (улсын, орон нутгийн чанартай, тусгай зориулалтын болон хурдны авто зам)	Засгийн газраас баталсан олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр, тухайн аймаг, нийспэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журмын дагуу, тусгай зориулалтын авто замд гэрээний дагуу төлнө.
13	Зээл, түрээсийн зардал (Байрны, автомашины түрээсийн гэх мэт)	Тухайн байгууллага, хувь хүн түрээслүүлэгч, зээл олгогч банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно.
14	Мэдээлэл, зар сурталчилгаа, интернет, үүрэн холбооны зардал	Өөрийн үйл ажиллагааг сурталчлах, ачаа тээврийн үйлчилгээний цахим програм ашиглан ачаа илгээгч, худалдан авагч наратай холбогдох ачаа хайх, үүрэн болон суурин холбоо, интернет хэрэглээний зардлыг гэрээний дагуу болон тухай бүр төлөх шаардлага үүсдэг
15	Томилолтын зардал	Сангийн сайдын баталсан тарифын хүрээнд жишиг болгон зардалдаа тусгах боломжтой
16	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд заасны дагуу
17	Агаарын бохирдлын төлбөр	Агаарын бохирдлын төлбөрийн тухай
18	Татвар (гаалийн, нэмэгдсэн өртөгийн, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар гэх мэт)	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль(Импортоор автомашин оруулж ирэх), Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай(тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас орсон орлого ), Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль(жил бүрийн тайлангаар)
19	Бусад нэмэлт зардал	Тухайн тээвэрлэлтийг зохион байгуулахад зайлшгүй шаардлагын улмаас гарч байгаа нэмэлт зардал

Тайлбар: Хүснэгт 1-ийн хүрээнд зардлыг мөнгөн дүнгээр болон нийт зардалд эзлэх хувиар нь тодорхойлж дүн шинжилгээ хийн цаащдын үр ашгийн тооцоонд ашиглах нь тээвэрлэлтийн зардлыг бууруулах үндэс болох юм. Энэхүү аргачлалаар холбогдох тооцоог хийхдээ, эрх зүйн баримт бичгүүдийн хамгийн сүүлд батлагдсан эх сурвалжыг ашиглах нь зүйтэй. Тээвэрлэгч нь өөрийн үйл ажиллагааны онцлогоос



хамааруулан өөр бусад зардлуудыг бодит нэхцэл байдалтай уялдуулан тусган төлөвлөж болно(Тухайлбал, автотээврийн хэрэгслийн зээл, барилга байгууламжийн зардал гэх мэт).

#### ГУРАВ. АЧААНЫ ЗЭРЭГЛЭЛЭС ХАМААРУУЛАН ТЭЭВРИЙН ХӨЛС ТООЦОХ

3.1. Автотээврийн хэрэгслээр тээсэн ачааны гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэлсийг тонн километр /тн.км/-ээр тодорхойлно.

3.2. Ачааны зэрэглэлийг тогтоохдоо, “Автотээврийн хэрэгслээр ачаа тээврлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ” MNS 5346 стандартын А хавсралтыг жишиг болгоно.

3.4. Даац ашиглалтын коэффициент нь автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчээс тогтоосон даацыг ачсан ачааны хэмжээнд харьцуулсан харьцаагаар тодорхойллогдоно.

- I. зэрэглэл — даац ашиглалтын коэффициент = 1,0;
  - II. зэрэглэл — даац ашиглалтын коэффициент = 0,71—0,99;
  - III. зэрэглэл — даац ашиглалтын коэффициент = 0,51—0,70.

3.5. Автомашинаар тээсэн ачааны тээвэрлэлтийн хэлс, орлогыг тооцоход тээврийн зий, ачааны хүндийг харгалзан, гүйцэтгэсэн нийт тонн километрийг 1тн.км-ийн тарифаар уржуулэн тооцно.

3.6. Ачаа тээврлэлтийн нийт зардлыг гүйцэтгэсэн ачаа эргэлт /тн.км/-д хувааж нэгжийн ёөрийн өртөг буюу 1 тн.км-ийн өртгийг тодорхойлно.

3.7. 1 тн.км-ийн тарифыг тооцохдоо, нэгжийн өөрийн өртөг дээр, нэгжийн ашгийг нэмэр.

3.8. Нийт орлогын тооцохдоо, 1 тн.км-ийн тарифыг гүйцэтгэсэн ачаа эргэлтээр уржгуулнэ.

3.9. Ачаа тээвэрлэлтийн тариф нь 1тн.км-ийн ажил гүйцэтгэх, өөрийн өртөг, энэхүү ажлыг гүйцэтгэнээс олох ашгийн нийлбэрээс бурдэнэ.

3.10. Автомашинаар тээвэрлэх ачааг үндсэн гурван зэрэгт (I, II, III, аргачлалын 3.4) ангилна.

3.11. Автомашинд I, II, III зэргийн ачааг хольж ачсан тохиолдолд тээврийн хэрэгслийн даацыг бүрэн ашигласан бол I зэргийн, даацад хүрээгүй бол II зэргийн ачааны тарифаар тооцно.

3.12. Тээвэрлүүлэгч, тээвэрлэгч байгууллагууд нь ачааны ангиллын жагсаалтыг баримтлан тээврийн хэлсийг тохиролцох нь зүйтэй.

3.13. Тээврийн зайн тооцохдоо, аймаг, хот хоорондын болон хот, сумын доторх батлагдсан авто замын сүлжээг баримтална.

3.14. Ачааг ачиж буулгах, бүртгүүлэх зэрэг ажиллагаатай холбогдуулан, аймаг, хот хоорондын авто замын сүлжээний батлагдсан км дээр, явалт тутамд Улаанбаатар хотод 30 хүртэл км, аймгийн төвд 8 хүртэл км, хот, бусад сум суурин газарт 2 км-ээр гүйлтийг нэмэгдүүлэн тооцож болох бөгөөд энэ нэмэгдэл км-т ногдох тээвэрлэлтийн ажлын хөлсийг тээвэрлүүлэгч, тээвэрлэгч байгууллага харилцан тохиролцно.

3.15. Автомшинаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэлсийг тонн километр /тн.км/-зэр тодорхойлох боломжгүй нэхцэлд автомшины даацыг харгалзан ажилласан цагаар нь тооцож болох бөгөөд энэ тохиолдолд 1 цагийн тарифыг байгууллага өөрсдөө тогтоон хэрэглэгч байгууллагатай тохиролцон мөрдөж болно.

3.16. Ачаа тээвэрлэх тарифыг энэхүү аргачлалын дагуу тооцож харилцан тохиороос гадна тээвэрлэлтийн гэрзэгээр тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газар хүргэх, тээврлүүлэгч нь хэлэлцэн тохирсон хөлс телэх үүргийг тус хүлээнэ.

3.17. Ачаа тээврэлзэтийн тариф тогтоохдоо, ачаа тээврийн 1тн.км-ийн жишигт тарифыг баримжая болгон зардал, орлого, ашгийн хэрэгцээг тайлан балансаар гарсан жинхэнэ гүйцэтгэл, санхүүгийн чадвар, ачааны зэрэг, ажил үйлчилгээний онцлог болон

Бүртэгжүүлэх төслийн  
багасгахад замжилж байсан  
ЗАМЖИЛСҮҮЛЭХ САЛБАРЫН  
ХУУЛСТДАР ҮНСЭН  
Хуулсын төслийн эжилтнүү гарын усаг  
Одигийн  
23 01 26 нийн одор

бусад хүчин зүйлийг харгалzan энэхүү аргачлалын дагуу тээвэрлэгч, тээвэрлүүлэгч Иргэний хуулийн хүрээнд харилцан тохиролцно.

3.18. Ашгийн хэрэгцээг байгууллагын санхүүгийн чадвар, зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил үйлчилгээний онцлогийг харгалzan аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тооцох бөгөөд жишиг тарифын тооцоон дээр 1 хүн.км-ийн ашгийг нэгжийн өөрийн өртгийн 10.0 хувиар, 1тн.км-ийн ашгийг 2.0-3.0 хувиар багагүй байхаар тооцох нь зүйтэй.

3.19. Аж ахуйн нэгж, байгууллагууд зардлын тооцоонд шатах, тослох материал, резин дугуй, сэлбэг хэрэгслийн хэрэгцээг тооцохдоо, байгууллага шатах, тослох материал, резин дугуй, сэлбэг хэрэгслийн норм норматив, урд онуудад зарцуулсан жинхэнэ гүйцэтгэл зэргийг харгалzan байгууллага өөрсдөө тооцно. Шатах, тослох материалын хэрэгцээг жишиг тарифын тооцоон дээр шатахууны 3.0-6.0 хувиас багагүй байхаар тооцдог.

3.20. Тээвэрлэлтийн шууд зардалд шатах тослох материалын зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл, цалин хэлс хамаарах тул эдгээр зардлуудыг (хүснэгт 1) дурдсан байдлаар тооцох нь зүйтэй.

3.21. Шатах, тослох материалын зардал, дугуйн элэгдлийг тооцохдоо "Жишиг норм батлах тухай" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад заасан 100км гүйлтэд зарцуулах шатахууны жишиг норм, мөн шатахууны бусад нэмэгдэл норм, хэмжээг баримтална.

3.22. Автомашины элэгдлийг тооцохдоо, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар тогтоосон хувь хэмжээ, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох аргачлал"-аар тооцно.



3.23. Жолоочийн цалинг засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажил үйлчилгээний онцлогоос хамаарч хөдөлмөрийн гэрээгээр тогтоох бөгөөд Автотээврийн салбарын хамтын тарифын хэлэлцээрээр тогтоосноос багагүй байна.

3.24. Томилолтын болон удирдлагын зардал, тээврийн хэрэгслийн татвар, даатгал, торгууль, авто зам ашигласны телбер зэргийг орхигдуулахгүй байх нь зүйтэй.

3.25. Өмнөх жилүүдэд автомашины элэгдлийг тооцохдоо, элэгдэл тооцох хугацааг 6 жил, жилийн элэгдэл тооцох хувь 16.6 байхаар зардалд оруулан тооцож төлөвлөж байсан ба Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.1. Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг машин, механизмын, техникийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж 10, бусад эд хөрөнгөд 10 жил байхаар заасныг харгалzan үзэх нь зүйтэй.

3.26. Бусад нэмэлт зардалд, тухайлбал битүүмжилсэн тээврийн багийн зохион байгуулалтад кемпийг байгуулахад оруулсан хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны явцад гарч буй урсгал зардал зэрэг зайлшгүй шаардлагын улмаас гарч байгаа нэмэлт зардлыг тооцож болно.



3.27. Энэхүү зөвлөмжийн дагуух тооцоо нь 1-р зэрэглэлийн ачааг тээвэрлэн 1тн.км ажил гүйцэтгэхэд шаардагдах зардал бөгөөд 2-зэрэглэлийн ачаанд 1-р зэрэглэлээс 30%-иар, 3-р зэрэглэлийн ачаанд 2-зэрэглэлээс 50%-иар нэмэгдүүлсэн дүнгээр тооцох боломжтой талаар холбогдох зөвлөмжүүдэд дурдсан байдаг.



**ДӨРӨВ. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАРДАЛ ТООЦОХ АРГАЧЛАЛЫН  
ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

Хүснэгт 2

д/д	Үзүүлэлтүүд	Ачаа тээвэрлэлтийн зардлыг тооцох томъёо:
1	Гүйцэтгэх ажилыг олоходоо	$(a \cdot q \cdot g) = q_2$
2	Хоногийн дундаж гүйлтийг олоходоо	(60км*8цаг)-олно.
3	Шатахууны үндсэн зарцуулалт, л	$(d \cdot p / 100) = p_2$
4	Хүйтний нэмэгдэл зөвхөн өвлүүний улиралд	шатахууны үндсэн зарцуулалтын 5%
5	Авто замын нөхцөлийн нэмэгдэл	Аль аймаг суманд ажиллахаас хамаарна. Жишээ нь Өвөрхангай аймаг 15%-иар нэмэгдэнэ.
6	100км-т зарцуулагдах шатахуун	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 болон 2 дугаар хавсралтын аргачлалын дагуу тооцно.
7	Нийт зарцуулах шатахуун, литр	$(p_2 + x + u + k) = p_{xu}$
8	Шатахууны нийт үнэ (₹-өөр)	$(p_{xu} \cdot m) = m_2$
9	Хөдөлгүүрийн тос, 1л	зах зээлийн үнээр
10	Шатах тосплох материал (шатахууны нийт үнийн 3%)	$(p_{xu} \cdot 0.03) = r_2$
11	Сэлбэг хэрэгсэл шатахууны нийт үнийн дүнгийн ( $m_2$ ) 10%	$(m_2 \cdot 0.10) = y$
12	Автомашины 1 өдрийн элэгдэл	$(f \cdot 0.1 / 365) = f_2$
13	Чиргүүлийн 1 өдрийн элэгдэл	$(h \cdot 0.1 / 365) = h_2$
14	1км-т оногдох дугуйн элэгдэл	$(b \cdot i / l) = i_1$ нийт дугуйн элэгдэл
15	Нийт элэгдлийн дүн	$(r_2 + y + f_2 + i_1 \cdot d) = f_{h2}$
16	Шууд зардалын дүн	$(m_2 + f_{h2}) = m_{fh}$
17	Бусад буюу тогтмол зардал (шууд зардалын 21%)	$(m_{fh} \cdot 0.21) = q_h$
18	Нийт зардал	$(m_{fh} + q_h) = W$
		$(W / g / a) =$ гарч ирнэ. (1-р зэрэглэлийн ачаа)
		2-зэрэглэлийн ачаа 1-р зэрэглэлээс 30%-иар илүү үнийн дүнгээр,
		3-р зэрэглэлийн ачаа 2-зэрэглэлээс 50%-иар илүү үнийн дүнгээр



ТАВ АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЗАРДЛЫГ ТОДОРХОЙ ЗАЙНД ТООЦСОН ЖИШЭЭ

Хүснэгт 3

Тээврийн хэрэгслийн марк: Mitsubishi Super Great


№	Тэмдэглэгээ	Өгөгдөл	Хэмжих нэгж	Үзүүлэлт, тоогоор
1	a	Тээврийн зай, нэг талдаа	км	430
2	b	Автомашин, чиргуулийн дугуйн тоо	ширхэг	8
3	c	Чиргуулийн жин	тонн	0
4	g	Ачааны жин	тонн	20
5	q	Ачаатай явалтын тоо	тоо	1
6	e	Гүйцэтгэх ажил	тн.км	8600
7	d	Нийт гүйлт	км	860
8	m	Шатахууны үнэ, 1 литр	төгрөг	4,030
9	f	Автомашины зах зээлийн үнэ	төгрөг	67,000,000
10	n	Автомашины гүйлтийн норм	км	350,000
11	h	Чиргуулийн үнэ	төгрөг	-
12	j	Чиргуулийн гүйлтийн норм	км	-
13	i	Дугуйн үнэ	төгрөг	750 000
14	l	Дугуйн гүйлтийн норм	км	50 000
15	z	Хоногийн дундаж гүйлт	км	430
16	o	Жолоочийн дундаж цалин /1 рейсийн/	төгрөг	155,000

Зарцуулалтууд

1		Шатахууны зардал		
2		Шатахууны төрөл	дизель	
3	s	Үндсэн норм Нс	литр	21
4	t	Чиргуулийн нэмэгдэл Нч	литр	0.00
5	x	Хүйтний нэмэгдэл Нх (5%)	литр	9.03
6	k	Гүйцэтгэсэн 100 тн.км тутамд зарцуулах шатахуун (1.725л)	литр	148.35
7	u	Автозамын нөхцөлийн нэмэгдэл Нз (15%)	литр	27.09
8	p	100 км-т зарцуулах шатахуун	литр	21
9	p2	Нийт гүйлтэд зарцуулах шатахуун	литр	180.6
10	pxu	Шатахуун зарцуулалт, нийт	литр	365.1
11	m2	Шатахууны нийт үнэ	төгрөг	1,471,232.1
12	г	Хөдөлгүүрийн тосны зах зээлийн үнэ 1л-ээр	төгрөг	
13	r2	Шатах тослох материал (шатахууны нийт үнийн 3%)	төгрөг	44,137.0
14	y	Сэлбэг хэрэгсэл (шатахууны нийт үнийн 10%)	төгрөг	147,123.2

Элэгдэл

1	f2	Автомашины элэгдэл 1 ёдрийн	төгрөг	18,356
2	h2	Чиргуулийн элэгдэл	төгрөг	-
3	i1	1км-оногдох дугуйн элэгдэл	төгрөг	120
4	fh2	Нийт элэгдэл үнийн дүн	төгрөг	312,816



МОНГОЛ УДСЫН  
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМ  
ЭХ ХУВЬ

5		Жолоочийн цалин, шимтгэл (12%)	төгрөг	18,600
6	mfh	Шууд зардлын дүн	төгрөг	467,816
7	qh	Бусад буюу тогтмол зардал (шууд зардлын 21%)	төгрөг	98,241.4
8	W	Нийт зардлын дүн	Төгрөг	2,037,289.9

## ЗУРГАА. ЗАРДЛЫН ТООЦООНД АШИГЛАЖ БОЛОХ НЭМЭЛТ ТОМЬЁОНУУД

6.1. Тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварт зарцуулах зардлын тооцоог дор дурдсан томъёогоор тодорхойлж болно:

$$Z_{\text{тыз}} = \frac{H_{\text{тыз}} * L_{\text{гүйлт}}}{1000}$$

Энд,  $Z_{\text{тыз}}$  - тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээнд зарцуулах зардал, төг,  $H_{\text{тыз}}$  - тухайн маркийн хөдлөх бүрэлдэхүүний техникийн үйлчилгээ, засварт зарцуулах норм, төг/1000 км,  $L_{\text{гүйлт}}$  - тээврийн хэрэгслийн гүйлт, км

6.2. Резин дугуйг нөхөн сэргээх, засварлахад шаардагдах зардлыг дугуйн үнийн дүнгээс тодорхой хувиар тооцон дараах томъёогоор тооцож болно.

$$Z_d = \frac{Y_d * H_d * n * L_{\text{ж.гүйлт}}}{100 * 1000}, \text{ төг,}$$

Энд,  $Y_d$  - дугуйн үнэ; төг,  $H_d$  - дугуйн 1000 км гүйлт тутамд засвар үйлчилгээнд зарцуулах норм, дугуйн үнийн дунд эзлэх хувиар (%),  $n$  - тухайн автотээврийн хэрэгслийн дугуйн тоо, ширхэг(нөөц дугуйг оролцуулахгүй);  $L_{\text{ж.гүйлт}}$  - тээврийн хэрэгслийн жилийн дундаж гүйлт, км

$$H_d = \frac{100\%}{H_{\text{норм}}}, \% / 1000 \text{ км,}$$

Энд,  $H_{\text{норм}}$  - тухайн маркийн дугуйн эдэлгээний норм, мянган.км, 100% - тухайн марк, хэмжээс бүхий дугуйн засвар үйлчилгээнд эзлэх хувь, %



6.3. Нэг жилд шаардагдах дугуйн хэрэгцээт тоог( $N_d$ ) дараах томъёогоор тодорхойлж болно.

$$N_d = L_{\text{ж.гүйлт}} * \frac{n}{H_{\text{норм}}}, \text{ ширхэг}$$

Энд,  $H_{\text{норм}}$  - тухайн маркийн дугуйн эдэлгээний норм, мянган.км;  $n$  - тухайн тээврийн хэрэгслийн дугуйн тоо, ширхэг(нөөц дугуйг оролцуулахгүй);  $L_{\text{ж.гүйлт}}$  - тухайн тээврийн хэрэгслийн жилийн дундаж гүйлт (ашиглалтын нөхцөлийг тооцно), км

6.4. Автотээврийн хэрэгслийн элэгдэл хорогдлыг дараах жишиг томъёогоор тодорхойлж болно.

$$\text{ЭХ} = \frac{1}{A_x * 12} * A_{6,7} * \text{Эхувь}$$



Энд, ЭХ - элэгдэл хорогдол, төг , Ах - Автотээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа, жил (элэгдлийн группын ангиллаар), Аб.у - Автотээврийн хэрэгслийн балансад бүртгэгдсэн үнэ, төг; Эхувь - Элэгдэл тооцох хувь, (Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд заасны дагуу)

## ДОЛОО. АЧААНЫ ЗЭРЭГЛЭЛ



1 дүгээр зэрэглэлийн ачаа: 2, 3 дугаар зэрэглэлд хамаардаггүй ачаа орно.

1.2. 2 дугаар зэрэглэлийн ачаа:

1.2.1. Үйлдвэрийн бараа:

1.2.2.

- 1.2.1.1. төрөл бүрийн бараа (гагнуурын ба шалгаж хянах, дугуй нөхөх, кино, эмнэлэг, холбоо, зургийн аппарат, түүний сэлбэг)
- 1.2.1.2. гадуур дотуур бэлэн хувцас
- 1.2.1.3. гутал (эсгий, савхин гутал, шаахай зэрэг)
- 1.2.1.4. даавуун эдлэл (сүлжмэл, ноосон, тортон)
- 1.2.1.5. жижиг бараа (хайрцагтай, боодолтой)
- 1.2.1.6. малгай, төрөл бүрийн
- 1.2.1.7. мотоцикл, дугуй
- 1.2.1.8. гэр ахуйн болон албан ажлын хэрэгцээний цахилгаан хэрэгсэл
- 1.2.1.9. сургалтын үзүүлэн материал
- 1.2.1.10. шилэн хэрэгсэл (эмнэлэг, лабораторийн)
- 1.2.1.11. шүдэнз
- 1.2.1.12. шил шаазан эдлэл, 200 мм-ээс дээш диаметртэй шилэн хоолойнууд
- 1.2.1.13. эм
- 1.2.1.14. даацанд хүргэж давхарлаж ачих боломжгүй, лааз савтай, тосон ба шороон будаг, лак, олиф
- 1.2.1.15. савтай болон автоцистернэй шатахуун, спирт, глицерин, олиф, битум, уусгагч хольцууд
- 1.2.1.16. хүрмэн чулуу, перлит, керамзит, полистрол
- 1.2.1.17. асбестан хоолой
- 1.2.1.18. хөнгөн бетон хоолой
- 1.2.1.19. хуудсан төмрөөр хийсэн агаар дамжуулах хоолой, салхивчны бусад эдлэлүүд
- 1.2.1.20. хөнгөн чанаарын керамзит, гипс, хөнгөн бетон, үнс, модны үртэс, зоргодос гэх мэт материалаар хийгдсэн хамар хана, бамбай зулавч хавтангууд
- 1.2.1.21. руберойд, толь пергамин, гидрозол, шалны хулдаас, ханын цаас (обой)
- 1.2.1.22. хөнгөн цагаан сав суулга ба бусад эдлэл задгай болон хайрцагтай
- 1.2.1.23. хавиргат хавтан, ханын хавтгаалж, шатны марш, худгийн цагираг, онгоц гэх мэт овор ихтэй барилгын төрөл бүрийн бетонон төмөр хавтан
- 1.2.1.24. холбооны агаарын шугамын 6 метрээс дээш урттай модон шон
- 1.2.1.25. барилгын хаалга, цонх
- 1.2.1.26. төрөл бүрийн кабель утас
- 1.2.1.27. хуванцар эдлэл
- 1.2.1.28. шаазан вааран хоолой
- 1.2.1.29. гэрлийн бүрхүүл
- 1.2.1.30. сантехник, цахилгааны зарим тоноглол, хэрэгсэл
- 1.2.1.31. шугам хоолой
- 1.2.1.32. төрөл бүрийн хаалт, арматур




- 1.2.1.33. зуух, даралтат сав, насос
- 1.2.1.34. тоног төхөөрөмж, техник хэрэгсэл
- 1.2.1.35. дулаалгын материал
- 1.2.1.36. мэдээлэл, харилцаа холбооны суваг, сувагчлалын материал, хийц эдлэлүүд
  
- 1.2.2. Хөдөө аж ахуй, хүнсний бараа
  - 1.2.1.1. гоймонгийн зүйл
  - 1.2.1.2. сүү (автоцистернтэй)
  - 1.2.1.3. талх (хайрцаг тавиур, контейнертэй)
  - 1.2.1.4. хүнсний ногоо (төмс орохгүй)
  - 1.2.1.5. хуурай жимс
  - 1.2.1.6. хиам, хиаман бүтээгдэхүүн
  - 1.2.1.7. хуурай сүү
  - 1.2.1.8. бог малын хавсарсан ба гулууз мах
  
- 1.2.3. Бусад ачаа
  - 1.2.3.1. яс
  - 1.2.3.2. тарих бут сөөг
  - 1.2.3.3. таар, шуудай, баглаа боодол болон бусад материалууд
  - 1.2.3.4. хаягдал төмөр, төмрийн зоргодос
  - 1.2.3.5. төрөл бүрийн савхи, нэхийгээр хийсэн хувцас
  - 1.2.3.6. төмөр болон паалан сав суулга

### 1.3. 3 дугаар зэрэглэлийн ачаа:

- 1.3.1. барилгын дулаалгын шилэн хөвөн, хөөсөнцөр материал, хийцууд
- 1.3.2. мебель, гэрийн эд хогшил, тооно
- 1.3.3. чийдэнгийн шил
- 1.3.4. ёд, ёден дэр
- 1.3.5. хөгжим, таазны чимэглэл
- 1.3.6. Төрөл бүрийн торх, лааз
- 1.3.7. модны үртэс, зоргодос
- 1.3.8. хайрцаг савтай нарийн боов, печень, торт
- 1.3.9. өндөг
- 1.3.10. архи, пиво, ундааны хоосон шил
- 1.3.11. төрөл бүрийн ангийн үс, үслэг эдлэл
- 1.3.12. ноос, ноолуур, хялгас, хөвөн (боодолтой)
- 1.3.13. сүрэл
- 1.3.14. өвс
- 1.3.15. уурын зуухны үнс, шланг
- 1.3.16. хүүхдийн тоглоом (Хайрцаг савтай)



### Ашигласан ном, эх сурвалжууд:

1. Бычков, В.П. Экономика автотранспортного предприятия: учебник. 2006.
2. Директивные и нормативные акты Российской Федерации по вопросам рыночной экономики, развитию транспорта.
3. Методические указания к справочно-нормативным материалам для курсового проектирования предприятий автотранспортного комплекса. Часть I. под ред. Седова И.А., МАДИ (ГТУ), 2003
4. БНМАУ-ын автотээврийн эдийн засаг (Т.Намжим. 1973),



5. "Автотээврийн эдийн засаг судлагчдад тусламж" (Б.Гомбожав, 1978),
6. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээврийн газар(хуучнаар)-аас хамтран эрхлэн хэвлэсэн "Автотээвэр" эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл,
7. Электрон техник, машин судлалын төвөөс 2012 онд эрхлэн хэвлүүлсэн "Автотээврийн ажилтны гарын авлага" (хянан тохиолдуулсан Д.Ёндонсүрэн) зэрэг ном товхимолыг гарын авлага болгон энэхүү аргачлалыг боловсруулсан болно.
8. "Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ" MNS 5346 стандарт
9. [https://studbooks.net/1767617/ekonomika/raschet\\_zatrata\\_toplivo\\_smazochnye\\_materialy](https://studbooks.net/1767617/ekonomika/raschet_zatrata_toplivo_smazochnye_materialy)

ооОоо





**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 1133

Улаанбаатар хот

**Зорчигч, ачаа тээвэрлэлтийн жишиг  
тариф шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Зорчигч тээвэрлэлтийн 1 хүн.км-ийн жишиг тарифыг нэгдүгээр хавсралтаар, ачаа тээвэрлэлтийн 1 тонн.км-ийн жишиг тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн баталсан жишиг тарифыг тээврийн хэрэгслийн төрлөөс хамааруулан үйлчилгээний гэрээнд тусган ажиллахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ (Б.Гүрсөронзон), тээвэрлэлтийн зардлыг тооцоход гарын авлага хэлбэрээр ашиглахыг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зөвлөсүгэй.

3. Энэхүү тушаал баталсантай холбогдуулан “Ачаа, зорчигч тээвэрлэлтийн жишиг тариф батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 374 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022  
оны 08 дугаар сарын 23 -ныгэдрийн 4/233  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



### ЗОРЧИГ Ч ТЭЭВЭРЛЭЛТИЙН 1 ХҮН.КМ-ИЙН ЖИШИГ ТАРИФ


№	Үзүүлэлт	Жишиг тариф /Төгрөг/
1	1 хүн.км-ийн жишиг тариф	75-150

#### Тайлбар:

Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний үнийн хөнгөлөлт нь зорчигч тээвэрлэх дүрмээр тодорхойлогдоно.

-----000-----





Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022  
оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 11:233  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

### АЧАА ТЭЭВЭРЛЭЛТИЙН 1 ТОНН.КМ-ИЙН ЖИШИГ ТАРИФ

№	Тээвэрлэлтийн зай	Ачааны зэрэг		
		I	II	III
1	1	1480	1924	2886
2	2	858.65	1116.2	1674.3
3	3	651.52	846.9	1270.3
4	4	547.96	712.3	1068.45
5	5	485.82	631.5	947.2
6	6	444.4	577.7	866.5
7	7	414.8	539.2	808.8
8	8	392.62	510.4	765.6
9	9	375.36	487.9	731.8
10	10	361.55	470	705
11	11-15	320.13	416.1	624.1
12	16-20	299.42	389.2	583.8
13	21-25	286.99	373	559.5
14	26-30	278.7	362.3	543.4
15	31-40	268.35	348.8	523.2
16	41-50	262.13	340.7	511
17	51-60	257.99	335.2	502.8
18	61-70	255.3	331.8	497.7
19	71-80	252.81	328.6	492.9
20	81-90	251.09	326.4	489.6
21	91-100	250.3	325.3	487.9
22	100-гаас дээш	248.58	323	484.5

#### Тайлбар:

Ачааны зэрэглэлийг тогтоохдоо, Автотээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ MNS 5346 стандартын А хавсралтыг жишиг болгоно.

-----000-----

